



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/383

Булган сум

**“Алтаргана 2024” наадмын бэлтгэл ажлын хүрээнд
Биеийн тамир, спортын газрын “А” заалны
тоног төхөөрөмжийн зардалд хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын XV их наадмын бэлтгэл ажлын хүрээнд Биеийн тамир, спортын газрын “А” заалны тоног төхөөрөмжийн зардалд 5,620,000 (таван сая зургаан зуун хорин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Гэрээ байгуулах эрхийг Биеийн тамир, спортын газрын дарга (Х.Батхишиг)-д олгож, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

3. Дээрх хөрөнгийг хавсралтаар баталж, орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
... дугаар сарын ... ны/ний өдрийн ... дугаар
захирамжийн хавсралт

Алтаргана 2024" олон улсын XV их наадмын бэлгэл ажлын хүрээнд Биеийн тамир,
спортын газрын "А" заалны тоног төхөөрөмжийн зардлын тооцоо

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	1	2	3	4
1	Биеийн тамир, спортын газрын "А" заалны яригч, фульт, микрфон	1 ком	4,000,000	4,000,000
2	Биеийн тамир, спортын газрын "А" заалны гадна талын туг	6ш	270,000	1,620,000
Нийт үнэ				5,620,000